| 210203 | ҮОМШӨ-ний даатгал | 2,751,100.00 | 2,751,100.00 |
| 210204 | Ажилгүйдлийн даатгал | 687,800.00 | 687,800.00 |
| 210205 | Эрүүл мэндийн даатгал | 6,877,900.00 | 6,877,900.00 |
| **2103** | **Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал** | 26,290,900.00 | 26,055,246.00 |
| 210301 | Гэрэл, цахилгаан | 2,530,900.00 | 2,295,246.00 |
| 210302 | Түлш, халаалт | 23,760,000.00 | 23,760,000.00 |
| 210303 | Цэвэр, бохир ус | | |
| 210304 | Байрны түрээс | | |
| **2104** | **Хангамж, бараа материалын зардал** | 52,547,500.00 | 48,598,400.00 |
| 210401 | Бичиг хэрэг | 4,325,000.00 | 2,879,100.00 |
| 210402 | Тээвэр, шатахуун | 45,615,800.00 | 43,406,900.00 |
| 210403 | Шуудан, холбоо, интернэтийн төлбөр | 1,395,100.00 | 1,214,200.00 |
| 210404 | Ном, хэвлэл | | |
| 210405 | Хог хаягдал зайлуулах, хортон мэрэгчдийн устгал, ариутгал | 1,211,600.00 | 1,098,200.00 |
| 210406 | Бага үнэтэй, түргэн элэгдэх, ахуйн эд зүйлс | | |
| 210407 | Аж ахуйн материал худалдан авах зардал | | |
| **2105** | **Нормативт зардал** | 158,308,900.00 | 144,957,809.00 |
| 210501 | Эм, бэлдмэл, эмнэлгийн хэрэгсэл | 124,694,500.00 | 112,744,409.00 |
| 210502 | Хоол, хүнс | 19,814,400.00 | 19,599,900.00 |
| 210503 | Нормын хувцас, зөөлөн эдлэл | 13,800,000.00 | 12,613,500.00 |
| **2106** | **Эд хогшил, урсгал засварын зардал** | 56,324,800.00 | 50,664,589.00 |
| 210601 | Багаж, техник, хэрэгсэл | 43,635,800.00 | 43,285,800.00 |
| 210602 | Тавилга | | |
| 210603 | Хөдөлмөр хамгааллын хэрэглэл | | |
| 210604 | Урсгал засвар | 12,689,000.00 | 7,378,789.00 |
| **2107** | **Томилолт, зочны зардал** | 930,000.00 | 750,000.00 |
| 210701 | Гадаад албан томилолт | | |
| 210702 | Дотоод албан томилолт | 930,000.00 | 750,000.00 |
| 210703 | Зочин төлөөлөгч хүлээн авах | | |
| **2108** | **Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж** | 451,400.00 | 328,000.00 |
| 210801 | Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж | | |
| 210802 | Аудит, баталгаажуулалт, зэрэглэл тогтоох | 300,000.00 | 300,000.00 |
| 210803 | Даатгалын үйлчилгээ | 17,800.00 | |
| 210804 | Тээврийн хэрэгслийн татвар | 46,500.00 | 28,000.00 |
| 210805 | Тээврийн хэрэгслийн оношлогоо | 19,000.00 | |
| 210806 | Мэдээлэл, технологийн үйлчилгээ | | |
| 210807 | Газрын төлбөр | 68,100.00 | |
| 210808 | Банк, санхүүгийн байгууллагын үйлчилгээний хураамж | | |
| 210809 | Улсын мэдээллийн маягт хэвлэх, бэлтгэх | | |
| **2109** | **Бараа үйлчилгээний бусад зардал** | 17,650,900.00 | 17,198,411.00 |
| 210901 | Бараа үйлчилгээний бусад зардал | 17,650,900.00 | 17,198,411.00 |
| 210902 | Хичээл үйлдвэрлэлийн дадлага хийх | | |
| **13** | **ЗАРДЛЫГ САНХҮҮЖҮҮЛЭХ ЭХ ҮҮСВЭР** | **722,352,600.00** | **701,486,276.00** |
| **1310** | **УЛСЫН ТӨСВӨӨС САНХҮҮЖИХ** | - | - |

| | | | |
|---|---|---|---|
| 131001 | Улсын төсвөөс санхүүжих | | |
| 131006 | Засгийн газрын тусгай сангаас санхүүжих | | |
| 131007 | Тусгай зориулалтын шилжүүлгээс санхүүжих | | |
| 131008 | Орон нутгийн хөгжлийн нэгдсэн сангаас санхүүжих | | |
| **1320** | **ОРОН НУТГИЙН ТӨСВӨӨС САНХҮҮЖИХ** | 29,229,900.00 | 28,749,146.00 |
| 132001 | Орон нутгийн төсвөөс | 29,229,900.00 | 28,749,146.00 |
| 132007 | Орон нутгийн хөгжлийн сангаас санхүүжих | | |
| **1340** | **НИЙГМИЙН ДААТГАЛЫН САНГИЙН ТӨСВӨӨС САНХҮҮЖИХ** | 693,122,700.00 | 672,737,130.00 |
| 134001 | Нийгмийн даатгалын сангаас санхүүжих | | |
| 134002 | Эрүүл мэндийн даатгалын сангаас санхүүжих | 693,122,700.00 | 672,737,130.00 |
| 134003 | Нийгмийн даатгалын сангаас эмнэлгүүдэд олгох санхүүжилт | | |
| **4** | **Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл** | | - |
| **5** | **Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эцсийн үлдэгдэл** | | 16,493,423.99 |
| **6** | **ТӨСВИЙН БУСАД МЭДЭЭЛЛИЙН АНГИЛАЛ** | | |
| **61** | **БАЙГУУЛЛАГЫН ТОО** | 1.00 | 1.00 |
| 610001 | Төсвийн байгууллага | 1.00 | 1.00 |
| 610002 | Төсвөөс гадуур байгууллага | | |
| **62** | **АЖИЛЛАГСАДЫН ТОО** | 21.00 | 24.00 |
| 620001 | Удирдах ажилтан | 1.00 | 1.00 |
| 620002 | Гүйцэтгэх ажилтан | 16.00 | 17.00 |
| 620003 | Үйлчлэх ажилтан | 4.00 | 6.00 |
| 620004 | Гэрээт ажилтан | | |
| **65** | **ОРОН ТООНЫ МЭДЭЭЛЭЛ** | **21.00** | **24.00** |
| 650001 | Төрийн захиргааны албан хаагч (ТЗ) | | |
| 650008 | Эрүүл мэндийн салбарын төрийн үйлчилгээний албан хаагч (ТҮЭМ) | 17.00 | 18.00 |
| 650009 | Төрийн үйлчилгээний бусад албан хаагч (ТҮ) | 4.00 | 6.00 |
| 650010 | Гэрээт ажилтан | | |
| 650011 | Улс төрийн албан хаагч (УТ) | | |

### 2.6 Аудит хийсэн нэмэлт төсвийн гүйцэтгэлийн тайлан

/ төгрөгөөр /

| Дансны код | Үзүүлэлт | Өмнөх он | Гүйцэтгэл |
|---|---|---|---|
| | **Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл** | | |
| **I** | **НИЙТ ЗАРЛАГА БА ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН** | **70,754,131.00** | **280,000.00** |
| **21** | **УРСГАЛ ЗАРДАЛ** | **70,754,131.00** | **280,000.00** |
| **210** | **БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ** | 70,754,131.00 | 280,000.00 |
| **2101** | **Цалин хөлс болон нэмэгдэл урамшил** | 52,318,000.00 | - |
| 210101 | Үндсэн цалин | | |
| 210102 | Нэмэгдэл | | |
| 210103 | Унаа хоолны хөнгөлөлт | | |
| 210104 | Урамшуулал | 52,318,000.00 | |
| 210105 | Гэрээт ажлын хөлс | | |
| **2104** | **Хангамж, бараа материалын зардал** | 2,823,731.00 | 100,000.00 |
| 210401 | Бичиг хэрэг | | |
| 210402 | Тээвэр, шатахуун | 2,823,731.00 | 100,000.00 |
| 210403 | Шуудан, холбоо, интернэтийн төлбөр | | |

| | | | |
|---|---|---|---|
| 210404 | Ном, хэвлэл | | |
| 210405 | Хог хаягдал зайлуулах, хортон мэрэгчдийн устгал, ариутгал | | |
| 210406 | Бага үнэтэй, түргэн элэгдэх, ахуйн эд зүйлс | | |
| **2105** | **Нормативт зардал** | 12,612,400.00 | - |
| 210501 | Эм, бэлдмэл, эмнэлгийн хэрэгсэл | 12,112,000.00 | |
| 210502 | Хоол, хүнс | 500,400.00 | |
| 210503 | Нормын хувцас, зөөлөн эдлэл | | |
| **2106** | **Эд хогшил, урсгал засварын зардал** | 3,000,000.00 | - |
| 210601 | Багаж, техник, хэрэгсэл | 3,000,000.00 | |
| 210602 | Тавилга | | |
| 210603 | Хөдөлмөр хамгааллын хэрэглэл | | |
| 210604 | Урсгал засвар | | |
| **2107** | **Томилолт, зочны зардал** | - | 180,000.00 |
| 210701 | Гадаад албан томилолт | | |
| 210702 | Дотоод албан томилолт | | 180,000.00 |
| 210703 | Зочин төлөөлөгч хүлээн авах | | |
| **II** | **ЗАРДЛЫГ САНХҮҮЖҮҮЛЭХ ЭХ ҮҮСВЭР** | 70,761,331.00 | 280,000.00 |
| **1311** | **Нэмэлт санхүүжилтийн орлого** | 70,761,331.00 | 280,000.00 |
| 131104 | Дээд шатны төсвийн захирагчийн төсөвт тусгагдсан төсвөөс доод шатны төсвийн захирагчид хуваарилсан хөрөнгө | 70,761,331.00 | 280,000.00 |
| 131105 | Төсвийн байгууллагын үндсэн үйл ажиллагааны хүрээнд бий болсон нэмэлт орлого | | |
| 131106 | Төсвийн урамшуулал | | |
| **IV** | **НИЙТ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (III)=(II)-(I)** | | |
| | Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл | | |
| | Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эцсийн үлдэгдэл | | |

## 3. САНХҮҮГИЙН ТАЙЛАНГИЙН ТОДРУУЛГА

### 3.1 Байгууллага, түүний үйл ажиллагаа

***Байгууллагын үйл ажиллагааны чиглэл, зорилго, зорилтын талаар***

Алтанцөгц сумын Эрүүл мэндийн төв нь анхан шатны тусламж, эмчилгээ үйлчилгээ үзүүлэх чиг үүрэг бүхий байгууллага.

Алтанцөгц сумын Эрүүл мэндийн төв нь 2022 онд “Эрүүл мэндийн хуулийн хуулийн дагуу сумын хүн амд эмнэлгийн анхны тусламж үйчилгээ үзүүлэх нийгмийн эрүүл мэндийн сургалт сурталчилгааны ажил явуулах “ гэсэн зорилго тавин ажиллаж байна.

Дээрх зорилгыг биелүүлэхээр дараах зорилтыг дэвшүүлэн ажилласан байна. Үүнд:

1. Эмнэлгийн эмч, мэргэжилтнүүд хэсэгчилсэн сургалтанд хамруулж, мэдлэг боловсролыг дээшлүүлэх, хүний нөөцийг хөгжүүлэх, тусгай төлөвлөгөөтэй ажиллах
2. Ажилтан албан хаагчдыг тогтвор суурьшилтай ажиллуулах, нийгмийн асуудылг шийдвэрлэхэд анхаарах
3. Эх, хүүхдийн эндэгдэл гарахаас урьдчилан сэргийлэх
4. Гэр бүл төлөвлөлтийн арга хэмжээг зохион байгуулж, НҮЭМ-ийн талаар тусгай төлөвлөгөөтэй ажиллах
5. Хүн амд эрүүл мэндийн боловсрол олгох, сургалт зохион байгуулах
6. Эм бэлдмэл, эмнэлгийн хэрэгсэл, хэрэгцээтэй тоног төхөөрөмжүүдийш санхүүгийн боломжоороо хангах
7. Халдварт өвчнөөс урьдчилан сэргийлэх, зорилтот бүлгийн хүмүүсийг байнга шинжилгэнэд хамруулах
8. Статистик мэдээ тайлан болон санхүүгийн тайлангуудаа цаг хугацаандаа холбогдох байгууллагуудад тайлагнаж байх
9. Эмнэлгийн эмч мэргэжилтний ёс зүй, дүрмийг чанд сахин, ард иргэдэд түргэн шуурхай үйлчилэх

### 3.2 Байгууллагын гадаад, дотоод орчин

***Байгууллагын үйл ажиллагаа явуулж буй хууль эрх зүйн орчны талаар***

Алтанцөгц сумын Эрүүл мэндийн төв нь Эрүүл мэндийн тухай хууль, Эрүүл мэндийн тусламж үйлчилгээний тухай хууль, Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль болон бусад холбогдох хууль тогтоомжуудыг үйл ажиллагаандаа мөрдөж ажилласан байна.

Тайлант хугацаанд байгууллагын үйл ажиллагаа, санхүү, нягтлан бодох бүртгэлд мөрддөг хууль тогтоомж болон бодлого чиглэлд өөрчлөлт ороогүй байна.

Байгууллагын удирдлагын хэрэгжүүлж буй дотоод хяналтаас төлөвлөлтийн үе шатанд аудитад хамааралтай хяналтыг авч үзэж, гүйцэтгэх үе шатанд хяналтын сорил гүйцэтгэсний үр дүнд дотоод хяналтын үйл ажиллагааны зохион байгуулалт, хэрэгжилт үр нөлөөтэй байна.

Байгууллагын 2022 оны нягтлан бодох бүртгэлийн үйл ажиллагааг зохих журмын дагуу хөтлөж, анхан шатны баримт материалыг зохих журмын дагуу бүрдүүлж, бараа материалын тайланг холбогдох хууль журмын дагуу гаргаж ажилласан байна.

Аймгийн Засаг даргын дэргэдэх Санхүүгийн хяналт, аудитын алба нь тус аймгийн төсөвт байгууллагуудын санхүү, бүртгэлийн үйл ажиллагаанд хяналт тавих чиг үүрэг бүхий байгууллага юм. Алтанцөгц сумын Эрүүл мэндийн төвийн нь 2020, 2021 оны үйл

ажиллагаанд шалгалтад хийж, 2022 оны санхүүгийн үйл ажиллагаан шалгалтад хамрагдаагүй тул дотоод аудитын гүйцэтгэсэн ажлыг аудитад ашиглах шаардлагагүй гэж үзлээ.

### 3.3 Санхүүгийн тайлагналын үзэл баримтлал

Санхүүгийн тайланг бүх материаллаг зүйлсийн хувьд холбогдох санхүүгийн тайлагналын үзэл баримтлалын дагуу бэлтгэсэн эсэх талаар аудитор дүгнэлтээ илэрхийлснээр санхүүгийн тайлангийн зорилтот хэрэглэгчдийн зүгээс үзүүлэх итгэл үнэмшлийн хэмжээг нэмэгдүүлэхэд санхүүгийн тайлангийн аудитын зорилго оршино.

Алтанцөгц сумын Эрүүл мэндийн төв нь 2022 оны санхүүгийн тайлан дахь ажил гүйлгээг аккруэл сууриар хөтөлж, нийтлэг зорилготой, үнэн зөв толилуулгын үзэл баримтлалын дагуу бэлтгэсэн байна.

***Байгууллагын мөрдөж буй нягтлан бодох бүртгэлийн бодлогын баримт бичгийн талаар***

Алтанцөгц сумын Эрүүл мэндийн төв нь Нягтлан бодох бүртгэлийн бодлогын баримт бичгийг боловсруулж, үйл ажиллагаандаа мөрддөг ажиллаагүй байна.

### 3.4 Нягтлан бодох бүртгэлийн гол бодлого, толилуулгад гарсан өөрчлөлтүүд

Алтанцөгц сумын Эрүүл мэндийн төвийн 2022 оны санхүүгийн тайланг Сангийн сайдын 2006 оны 388 дугаар тушаалаар баталсан “Төсөвт байгууллагад мөрдөх нягтлан бодох бүртгэлийн дансны заавар”-ын дагуу бэлтгэсэн байна.

Тайлант хугацаанд нягтлан бодох бүртгэлийн бодлогод өөрчлөлт ороогүй байна.

Тайлант оны жилийн эцсийн санхүүгийн байдлын тайлангаарх нийт хөрөнгийн дүн өмнөх оноос 2,186.9 сая төгрөгөөр буюу 9.5 хувиар өссөн байна.

*Хүснэгт 1. Санхүүгийн байдлын тайлангийн үзүүлэлт*

/мянган төгрөгөөр/

| Үзүүлэлт | Эхний үлдэгдэл | Эцсийн үлдэгдэл | Өөрчлөлт |
|---|---|---|---|
| Б | 1 | 2 | 3=2-1 |
| Мөнгөн хөрөнгө | - | 16,493.4 | 16,493.4 |
| Авлага | 73,946.6 | - | 73,946.6 |
| Урьдчилгаа | - | - | |
| Бараа материал | 51,805.9 | 123,920.9 | -72,115.0 |
| Үндсэн хөрөнгө | 855,628.3 | 964,489.0 | -108,860.7 |
| **Нийт хөрөнгө** | **981,380.7** | **1,104,903.4** | **-123,522.7** |
| Өр төлбөр | | | |
| Засгийн газрын хувь оролцоо /Эздийн өмч/ | 951,336.0 | 1,104,903.4 | 153,567.7 |
| **Өр төлбөр ба цэвэр хөрөнгө/өмчийн дүн** | **981,380.7** | **1,104,903.4** | **153,567.7** |

Дээрх хүснэгтээс харахад мөнгөн хөрөнгө, бараа, материал, үндсэн хөрөнгө дансанд өмнөх оны үзүүлэлтээс нөлөө бүхий өөрчлөлт гарсан байна.

Алтанцөгц сумын Эрүүл мэндийн төв нь оны эцэст улсын төсвөөс авсан санхүүжилтээс 16.5 сая төгрөгийн хэмнэлт гаргаж, оны эцэст харилцах дансны үлдэгдлээр тайлагнасан байна.Тайлант онд авлага үүсгэж ажиллаагүй байна.

Бараа материалын үлдэгдэл өнгөрсөн оны үлдэгдлээс 72.1 сая төгрөгөөр нэмэгдсэн байна.Тайлант онд 174.9 сая төгрөгийн бараа материалыг төсвийн хөрөнгөөр худалдан авч, үнэ төлбөргүй 49.7 сая төгрөгийн бараа материалыг хүлээн авч, үйл ажиллагаандаа 152.3 сая төгрөгийн бараа материалыг зарцуулж, тайлант хугацаанд ашиглалтын хугацаа дууссан 0.2 сая төгрөгийн бараа материалыг акталж, оны эцэст 123.9 сая төгрөгийн бараа материалын үлдэгдэлтэй гарсан байна.

Үндсэн хөрөнгө 108.9 сая төгрөгөөр өссөн байна.Тайлант онд төсвийн хөрөнгөөр 41.4 сая төгрөгийн үндсэн хөрөнгийг худалдан авч, тайлант онд бусад эх үүсвэрээр үнэ төлбөргүй ирсэн 12.9 сая төгрөгийн үндсэн хөрөнгийг, хөрөнгө оруулалтаар 94.9 сая төгрөгийн их засвар хийгдснийг дансанд бүртгэсэн байна. Тайлант онд акталж устгасан үндсэн хөрөнгө байхгүй байна. Тайлант онд үндсэн хөрөнгөд 40.5 сая төгрөгийн элэгдэл байгуулсан байна.

Тайлант онд үр дүнгийн тайлан 153.6 сая төгрөгийн үр дүнтэй гарч, Засгийн газрын хувь оролцоо данс 153.6 сая төгрөгөөр нэмэгдсэн байна.

### 3.5 Төсвийн төлөвлөлт, гүйцэтгэл, нэмэлт төсөв

Төсвийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.1-д заасны дагуу төсвийг төлөвлөх, хэрэгжүүлэх, тайлагнахад эрх бүхий байгууллага, төсвийн захирагч нь тус хуулийн 5 дугаар зүйлийн 5.1-д заасан төсвийн зарчмыг мөрдлөг болгож, хэрэгжүүлэх үүрэгтэй.

#### 3.5.1 Төсвийн төлөвлөлт

Тус байгууллагын 2022 оны төсвийн төсөлд зардлыг санхүүжүүлэх эх үүсвэрийг тоон дүнгээр илэрхийлээгүй,Эрүүл мэндийн газарт статистик тоо мэдээг өгч ажилласан байна. Эрүүл мэндийн төвүүд нь гүйцэтгэлээр Эрүүл мэндийн даатгалаас санхүүжилт авдаг болж өөрчлөгдсөнтэй холбоотой 2022 онд Эрүүл мэндийн даатгалын сангаас 672.7 сая төгрөгийн, орон нутгийн төсвөөс 29.2 сая төгрөгийн санхүүжилтийг авсан байна.

#### 3.5.2 Төсвийн гүйцэтгэл

Төсвийн захирагчийн хэрэгжүүлэх 2 хөтөлбөрийн 9 арга хэмжээг санхүүжүүлэхээр Эрүүл мэндийн даатгалын сангаас 693.1 сая төгрөгийн, орон нутгийн төсвөөс 29.2 сая сая төгрөгийн, бүгд 722.3 сая төгрөгийн санхүүжилтийг бүрдүүлэхээр тусгасан байна.

Гүйцэтгэлээр улсын төсвөөс 672.7 сая төгрөгийн, орон нутгийн төсвөөс 29.2 сая төгрөгийн, нийт 701.9 сая төгрөгийн санхүүжилтийг олгосон байна. Төсвийн нийт зардлын гүйцэтгэл 685.0 сая төгрөг буюу 94.8 хувьтай байна. Тайлант онд орон нутгийн төсвөөс хэмнэгдсэн 0.5 сая төгрөгийн төсөвт төвлөрүүлэн, Эрүүл мэндийн даатгалын санхүүжилтээс хэмнэгдсэн 16.5 сая төгрөгийн төсвийг төрийн сангийн үлдэгдэлд тайлагнасан байна.

*Хүснэгт 2. Хөтөлбөр, арга хэмжээний төлөвлөгөө, гүйцэтгэл*

/мянган төгрөгөөр/

| д/д | Хөтөлбөр, арга хэмжээ | Төлөвлөгөө | Гүйцэтгэл | Зөрүү | Биелэлт |
|---|---|---|---|---|---|
| 1 | Нэг иргэнд ногдох нормативаар | 636,945.0 | 599,585.20 | 37,359.80 | 94.13% |

| | | | | | |
|---|---|---|---|---|---|
| 2 | нэмэлт-дээд шатны төсвөөс хуваарилсан | 85,687.60 | 85,687.60 | - | 100.00% |
| | **Дүн** | **722,632.60** | **685,272.80** | **37,359.80** | **94.83%** |

Батлагдсан төсөв, гүйцэтгэл, түүний хэтрэлт, хэмнэлтийг орлого, зардлын зүйл тус бүрээр энэ тайлангийн 2.5-д харуулав.

### 3.5.3 Нэмэлт төсөв

Төсвийн тухай хуулийн 47 дугаар зүйлийн 47.2-т “нэмэлт төсөв, түүнтэй холбогдсон үйл ажиллагаа нь төсвийн нэгэн адил санхүүгийн болон төсвийн гүйцэтгэлийн тайлангийн бүрэлдэхүүн хэсэг байна” гэж заасны дагуу байгууллага нэмэлт санхүүжилтийн тайлан гаргах үүрэгтэй.

Алтанцөгц сумын Эрүүл мэндийн төв  нь тайлант онд 0.2 сая төгрөгийн нэмэлт санхүүжилт авч, дотоод албан томилолтод 0.18 сая төгрөгийг, 0.1 сая төгрөгийг шатахууны зардалд зарцуулсан байна.

### *3.5.4 Төсөл хөтөлбөрийн үе шат, хүрэх үр дүн*

Алтанцөгц сумын ерөнхий Эрүүл мэндийн төв  нь 2022 онд төсөл хөтөлбөр хэрэгжүүлээгүй байна.

## 4. АУДИТЫН ТАЙЛАН

### 4.1 Ерөнхий зүйл

Төрийн аудитын тухай хуулийн 20 дугаар зүйлийн 20.1-д “Төрийн аудитын байгууллага аудитын дүнд үндэслэн дүгнэлт, зөвлөмж бүхий аудитын тайлан гаргана” гэж заасны дагуу Баян-Өлгий аймгийн Алтанцөгц сумын Эрүүл мэндийн төвийн  2022 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудитын тайланг танилцуулж байна.

Аудитын тайланд аудит хийгдэх байгууллага, түүний орчин, аудитад хамааралтай дотоод хяналт, нягтлан бодох бүртгэл, санхүүгийн тайлагналын үзэл баримтлал, аудитаар илрүүлсэн буруу илэрхийлэл, түүнийг шийдвэрлэсэн байдал, дараагийн аудитаар анхаарах асуудал болон аудиторын дүгнэлт, дүгнэлтийн үндэслэлийг хураангуйлан толилуулав. Мөн байгууллагын үйл ажиллагааг сайжруулах хууль тогтоомжийн хэрэгжилт, бүртгэл тайлагналтай  холбоотой өгсөн зөвлөмжүүдийг тусгасан болно.

Аудитыг аймаг дахь Төрийн аудитын газрын ахлах аудитор М.Айнур гүйцэтгэж, хяналтыг аудитын менежер Х.Женисбек, дарга, тэргүүлэх аудитор М.Хуанган нар тус тус хэрэгжүүлсэн.

Алтанцөгц сумын Эрүүл мэндийн төвийн  2022 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийн тайланг аймаг дахь Төрийн аудитын газарт 2023 оны 01 дүгээр сарын 24-ны өдрийн А/07 дугаартай албан бичгээр ирүүлсэн байна.

### 4.2 Материаллаг байдал

Төлөвлөлтийн болон гүйцэтгэлийн материаллаг байдлыг АДБОУС 2320 дагуу тодорхойлсон бөгөөд материаллаг байдлын суурь үзүүлэлтээр нийт зардлыг сонгож, материаллаг буруу илэрхийллийн эрсдэлийг дунд гэж үнэллээ.

Төлөвлөлтийн материаллаг байдлыг Алтанцөгц сумын Эрүүл мэндийн төвийн 2021 оны санхүүгийн үр дүнгийн тайлангийн нийт зардлын 546.6 сая төгрөгөөс 1.5 хувиар буюу 8.2 сая төгрөгөөр, тогтоосныг аудитын явцад дахин хянаж шинэчлэн тогтоох шаардлагатай гэж үзсэн.

Гүйцэтгэх үе шатанд материаллаг байдлыг Алтанцөгц сумын Эрүүл мэндийн төвийн 2022 оны санхүүгийн үр дүнгийн тайлангийн нийт зардлын 632.5 сая төгрөгөөс 1.5 хувиар буюу 9.5 сая төгрөгөөр байсан ба гүйцэтгэлийн шатанд материаллаг түвшинг шинэчлэн тогтоох шаардлагагүй гэж үзлээ.

### 4.3 Төрийн хэмнэлтийн тухай хуулийн хэрэгжилт

Төрийн хэмнэлтийн тухай хууль хэрэгжиж эхэлсэнтэй холбоотойгоор байгууллага батлагдсан төсөвтөө багтаан үйл ажиллагаа явуулсан байна.

Төрийн хэмнэлтийн тухай хуулийн хэрэгжилтийг шалгаж жилийн турш Бек Импекс ХХК-наас 4 удаагийн гүйлгээгээр 25.2 сая төгрөгийн, Мед буян ХХК-наас 2 удаагийн гүйлгээгээр 16.3 сая төгрөгийн бараа материал, үндсэн хөрөнгийг шууд гэрээгээр худалдан авсан байна. Жилийн дүнгээр 10.0 сая төгрөгнөөс дээш үнэтэй барааг худалдаж авах тохиолдолд цахим дэлгүүрт хандаж ажиллах талаар албан шаардлага өгөгдлөө.

### 4.4 Санхүүгийн тайлангийн аудитаар шалгасан нийцлийн аудитын асуудал

АДБОУС 4000.16-д нийцлийн аудитыг санхүүгийн тайлангийн аудиттай хослуулан хийх тохиолдолд аудитор аль стандартыг дагаж мөрдөхийг үнэлэх, нийцлийн асуудлын талаарх дүгнэлтийг санхүүгийн тайланд өгөх аудиторын дүгнэлтээс тусад нь салгах хэрэгтэй гэж заасан байна.

#### 4.4.1 Шилэн дансны тухай хуулийн хэрэгжилт

Шилэн дансны тухай хуулийн 6 дугаар зүйл, Засгийн газрын 2016 оны 29 дүгээр тогтоолоор баталсан “Шилэн дансны цахим хуудсанд тавих мэдээллийн агуулга, нийтлэг стандартыг тогтоох журам”-ын заалтыг хэрэгжүүлэх зорилгоор www.shilendans.gov.mn цахим хуудсанд холбогдох мэдээллийг оруулсан байх үүрэгтэй.

Тайлант онд Шилэн дансны мэдээллээс шалгах программд орсон мэдээллүүдийн хэрэгжилтийг шалгав.

Шилэн дансны тухай хуулийн хэрэгжилтийг шалгаж үзэхэд 6 гүйлгээгээр гарсан 47.9 сая төгрөгийн зарлагыг, төсөв мөнгөтэй холбоотой 24 тушаал шийдвэрийг цахим хуудсанд байршуулаагүй байсанд албан шаардлага өгөгдлөө. Дээрхи зөрчлийн улмаас шилэн дансны мэдээлсэн байдлын хэрэгжилтийн хувь 62.5 хувьтай байна.

Аудитын дүнгээр шилэн дансны зөрчилд албан шаардлага өгөгдлөө.

### 4.5 Завсрын аудитын үр дүн, өмнөх зөвлөмжийн хэрэгжилт

#### 4.5.1 Завсрын аудитын талаар

Завсрын аудитаар эхний хагас жилийн санхүүгийн баримтад түүвэр хийгдээгүй байна.

### 4.5.2 Өмнөх аудитын мөрөөр авч хэрэгжүүлсэн арга хэмжээний үр дүн

Өмнөх аудитын дүнгээр төлбөрийн акт тогтоогоогүй, албан шаардлага, зөвлөмж өгөгдөөгүй байна.

*Хүснэгт 4* Төлбөрийн акт, албан шаардлага, зөвлөмжийн хэрэгжилт

/мянган төгрөгөөр/

| Үзүүлэлт | Өмнөх аудитын үзүүлэлт | | Биелэлт | | |
|---|---|---|---|---|---|
| | Тоо | Дүн | Тоо | Дүн | Хувь |
| Акт | 0 | 0 | | | |
| Албан шаардлага | 0 | 0 | 0 | 0 | 0 |
| Зөвлөмж | 3 | 25.5 | 3 | 25.5 | **100%** |
| **Нийт дүн** | **3** | **25.5** | **3** | **25.5** | **100%** |

### 4.6 Дараагийн аудитаар анхаарах асуудал

Дараагийн аудитаар эмийн зардал, аж ахуйн зардлын зарцуулалтыг үзэх шаардлагатай.

## 5. АУДИТЫН ИЛРҮҮЛЭЛТ

Аудитаар санхүүгийн тайланд 94.9 сая төгрөгийн залруулга хийгдсэн. Үүнд үр дүнгийн тайланд эмнэлгийн барилгад хийгдсэн 94.9 сая төгрөгийн их засварыг нэмэлт санхүүжилтийн орлогоор тайлагнасныг аудитын явцад залруулав.

Аудитын дүнгээр 92.2 сая төгрөгийн зөрчил илэрснээс 92.2 сая төгрөгийн албан шаардлага өгөгдсөн.

### 5.1 Төлбөрийн акт

Төлбөрийн акт байхгүй.

### 5.2 Албан шаардлага

Аудитын дүнгээр дараах зөрчилд албан шаардлага өгөгдлөө. Үүнд:

1. Эмийн санчийн эм, боох материалын орлого, зарлагын тайланг нягтлан бодох бүртгэлийн журналаас зөрүүтэй гаргасан, аж ахуйн бараа материалын тайланг данс тус бүрээр хөтлөөгүй нэгтгэж гаргасан, бэлтгэн нийлүүлэгчээс ирүүлсэн анхан шатны баримтыг бүрэн хавсаргаагүй, нярвын тооцоонд тавих дотоодын хяналтыг хангалтгүй, худалдан авсан эм, аж ахуй, хоол, шатахууны бараа материалын дийлэнх хэсгийн цахим төлбөрийн баримтыг бүрдүүлж хавсаргаагүй.

2. “Бек Импекс” ХХК-наас 25.1 сая төгрөгийн, “Мед буян” ХХК-наас 16.3 сая төгрөгийн бараа материал, үндсэн хөрөнгийг шууд гэрээгээр худалдан авсан.

3.Шилэн дансанд төсөв, мөнгө хөрөнгөтэй холбоотой 24 тушаал шийдвэр, 5.0 сая төгрөгөөс дээш 47.9 сая төгрөгийн 6 гүйлгээг мэдээлээгүй зөрчилд албан шаардлага өгөгдлөө.

### 5.3 Зөвлөмж

Зөвлөмж өгөгдөөгүй.

Дээрх албан шаардлагын биелэлтийг Төрийн аудитын байгууллагад 2023 оны 10 дугаар сарын 01-ны өдрийн дотор ирүүлнэ үү.

Аудитын явцад бидэнтэй хамтран ажилласан холбогдох ажилтнуудад талархал илэрхийлье.

## 6. АУДИТААР ИЛЭРСЭН БУРУУ ИЛЭРХИЙЛЛИЙН НЭГТГЭЛ

### Санхүүгийн тайлангийн аудитын алдааны нэгтгэл

/мянган төгрөгөөр/

| Алдааны товч утга | Нийт алдаа | | Мэдээллийг тусгахгүй орхигдуулсан | | Буруу тусган илэрхийлсэн | | Үүнээс | | | | Зөвлөмж | |
|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|
| | | | | | | | Залруулсан | | Залруулаагүй | | | |
| | Тоо | Дүн | Тоо | Дүн | Тоо | Дүн | Тоо | Дүн | Тоо | Дүн | Тоо | Дүн |
| Санхүүгийн тайланг алдаатай илэрхийлсэн | 1 | 94,986.4 | | | 0 | 0 | 1 | 94,986.4 | | | | |
| **Дүн** | **1** | **94,986.4** | | | **0** | **0** | **1** | **94,986.4** | | | | |

### Санхүүгийн тайлангийн аудитын зөрчлийн нэгтгэл

/мянган төгрөгөөр/

| Зөрчлийн товч утга | Нийт зөрчил | | Үүнээс | | | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|
| | | | Төлбөрийн акт | | Албан шаардлага | | Зөвлөмж | | Хариуцлага тооцуулах албан шаардлага | | Хууль, хяналтын байгууллагад шилжүүлсэн асуудал | |
| | Тоо | Дүн | Тоо | Дүн | Тоо | Дүн | Тоо | Дүн | Тоо | Албан тушаалтны тоо | Тоо | Дүн |
| Аж ахуйн бараа материалын тайланг данс тус бүрээр хөтлөөгүй нэгтгэж гаргасан | 1 | 2822.2 | | | 1 | 2822.2 | - | - | | | | |
| **Дүн** | 1 | 2822.2 | | | 1 | 2822.2 | - | - | | | | |

### Санхүүгийн тайлангийн аудитаар шалгасан нийцлийн аудитын асуудал

/мянган төгрөгөөр/

| Зөрчлийн товч утга | Нийт зөрчил | | Үүнээс | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|---|
| | | | Төлбөрийн акт | | Албан шаардлага | | Зөвлөмж | |
| | Тоо | Дүн | Тоо | Дүн | Тоо | Дүн | Тоо | Дүн |
| Шилэн дансны тухай хуулийн хэрэгжилттэй холбоотой зөрчил | | | | | | | | |
| Шилэн дансны цахим хуудсанд мэдээллийг дутуу байршуулсан | 1 | 47892.3 | | | 1 | 47892.3 | 1 | - |
| **Дүн** | 1 | 47892.3 | | | 1 | 47892.3 | 1 | 0 |
| Төрийн хэмнэлтийн тухай хууль тогтоомжтой холбоотой зөрчил | | | | | | | | |
| Цахим дэлгүүрээс бусад газраас бараа худалдаж авсан | 1 | 41514.9 | | | 1 | 41514.9 | 0 | |
| Дүн | 1 | 41514.9 | | | 1 | 41514.9 | 0 | |
| **Нийт дүн** | **2** | **89407.2** | | | **2** | **89407.2** | **0** | **0** |